



I-V/2021

Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 13




Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 5 дугаар сард Говь-Алтай аймгийн Шарга сум, Баянхонгор аймгийн Шинэжинст сумд тус бүр $+35^{\circ}\text{C}$ -д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 5 дугаар сард Говь-Алтай аймгийн Шарга сум, Баянхонгор аймгийн Шинэжинст сумд тус бүр $+35.0^{\circ}$, үнэмлэхүй бага температур Говь-Алтай аймгийн Төгрөг сум, Хөвсгөл аймгийн Улаан-Уул суманд -12.0°C -д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР ($^{\circ}\text{C}$), ОЛОН ЖИЛИЙН ДУНДАЖТАЙ¹ ХАРЬЦУУЛСНААР, станцын байршлаар, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар



¹ - 1981-2010 он


Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 5 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Булган аймгийн Сэлэнгэ сумын нутгаар 68.4 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Говь-Алтай аймгийн Бугат сумын нутгаар түр зуур 41 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хий болон азотын давхар ислийн сарын дундаж агууламж 2021 оны 5 дугаар сард агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна.


Харин РМ 10 тоосонцрын сарын дундаж агууламж 2021 оны 5 дугаар сард Баянхошуу орчимд 0.115 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.015 мг/м³ -ээр давсан байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ PM 10 ТООСОНЦРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, станцаар, мг/м³



Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисуудын дундаж агууламжийг авч үзвэл, 2021 оны 5 дугаар сард азотын давхар исэл өмнөх оны мөн үеэс 0.012 мг/м³ (34.7%)-ээр, өмнөх сараас 0.001 мг/м³ (5.0%)-ээр, PM 2.5 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.004 мг/м³ (23.4%)-ээр, өмнөх сараас 0.002 мг/м³ (16.7%)-ээр, PM 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.016 мг/м³ (21.7%)-ээр, өмнөх сараас 0.007 мг/м³ (10.9%)-ээр тус тус бага байсан бол хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.010 мг/м³ (2.2 дахин)-ээр их, өмнөх сараас 0.017 мг/м³ (46.4%)-ээр бага байна.

ЗУРАГ 3. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 5 дугаар сарын байдлаар, мг/м³



ХҮСНЭГТ 1. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАХ БОДИСЫН АГУУЛАМЖ АГААРЫН ЧАНАРЫН СТАНДАРТ ХҮЛЦЭХ АГУУЛАМЖААС ДАВСАН ТОХИОЛДЛЫН ТОО, станцаар, 2021 оны 5 дугаар сард

| Станцын байршил | Хүхэрлэг хий (SO ₂) | Азотын давхар исэл (NO ₂) | Тоос (PM ₁₀) | Тоос (PM _{2.5}) | Озон (O ₃) |
|------------------------|---------------------------------|---------------------------------------|--------------------------|---------------------------|------------------------|
| Мишээл экспо | 2 | 1 | 3 | - | - |
| Баруун 4 зам | 2 | 11 | 1 | - | - |
| 1-р хороолол | 7 | - | 3 | - | - |
| 13-р хороолол | - | 1 | 2 | - | - |
| 32-ын тойрог | - | - | 4 | - | - |
| Хархорин | - | - | 13 | - | - |
| Ургах наран хороолол | - | - | 2 | - | - |
| 248-р цэцэрлэг | - | - | 3 | 8 | - |
| Богд хааны ордон музей | - | - | 1 | - | - |
| Нисэх | - | - | - | - | 3 |
| Толгойт | - | - | - | - | 4 |
| Зурагт | 3 | - | - | - | - |
| Амгалан | - | - | 1 | - | 1 |
| Баянхошуу | - | - | 14 | - | - |

Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 5 сард 1782 болж, өмнөх оны мөн үеэс 524 (22.7%)-гоор буурсан байна. Объектын түймэр 1214 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 489 (28.7%)-өөр буурсан байна.

Улсын хэмжээнд 2021 оны эхний 5 сард мал, амьтны халдварт галзуу өвчний 11, шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 45229 тохиолдол тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 2. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2018 I-V | 2019 I-V | 2020 I-V | 2021 I-V | <u>2021 I-V</u> <u>2020 I-V</u> |
|----------------------------------|---------------|----------|----------|----------|----------|------------------------------------|
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдол | тоо | 2 156 | 2 690 | 2 306 | 1 782 | 77.3 |
| Амь насаа алдсан хүн | тоо | 60 | 66 | 73 | 370 | 5.1 ¹ |
| Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн | тоо | 31 | 34 | 218 | 45 283 | 207.7 ¹ |
| Шатсан гэр, орон сууц | тоо | 767 | 887 | 825 | 355 | 42.7 |
| Объектын түймэр | тоо | 1 742 | 2 275 | 1 703 | 1 214 | 71.3 |
| Учирсан хохирол | тэрбум төгрөг | 14.2 | 5.5 | 104.3 | 10.0 | 9.6 |
| Зарцуулсан зардал | сая төгрөг | 9 925.8 | 1 012.9 | 167.5 | 1.6 | 1.0 |

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 5 сард нийт 370 хүн амь насаа алдаж өмнөх сараас 165 (80.5%)-аар , 45283 хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон хүний тоо өмнөх сараас 22051 (1.9 дахин)-аар нэмэгдсэн байна.

Амь насаа алдсан шалтгааныг нь авч үзэхэд бичил уурхай, нурангийн улмаас 4 хүн, усны ослоор 17 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн, объектын түймрийн улмаас 33 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 276 хүн, бусад золгүй явдлын улмаас 29 хүн амь насаа алджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 5 сард 355 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 473 (57.3%)-аар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 5 сард 10.0 тэрбум төгрөгийн хохирол учирч, 1.6 сая төгрөг зарцуулсан байна.

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний 5 сард 1816 хүнийг аварч, 37.0 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар



Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 7 дугаар сарын 19

Эдийн засгийн статистикийн
газрын дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн
газрын статистикч Г.Цэвэлмаа
Утас : (976-51)-261563